



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА **Д.ДАВААНЯМ**

2025 ОН

АГУУЛГА

Нэг.Зорилт.....	3
Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/.....	3
Гурав. Бүртгэлийн үйл ажиллагаа	9
3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :	9
3.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	10
3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	13
3.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа	15
Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд	17
Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	17
Зургаа. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт.....	21
Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан /Байгууллагын цахим хуудас, санхүүгийн үйл ажиллагаа/.....	22
Найм. Сургалтын төлөвлөгөө тайлагнах ажлын хүрээнд	24
Ес. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/	28
Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил.....	33

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Зорилт

Тус хэлтэс нь 2025 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө, “Алсын хараа-2050”, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай хүргэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/

Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, байгууллагын бодлого, стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, үүрэг даавгаврын биелэлтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын биелэлтийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх, хөтөлсөн бүртгэлийг тухай бүр цахимжуулах, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан бичиг, чиглэл, зөвлөмжийг албан хаагчдад хамт олны хурлаар тухай бүр тогтмол танилцуулан, тайлант хугацаанд 11 удаа хурал хийсэн байна.

Мөн тус хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил болон 3 дугаар улирлын явцын үнэлгээг хийж Бодлого, төлөвлөлт дүн шинжилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр 1/9149 дугаар албан бичгээр ирүүлсний дагуу албан хаагчтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллав.

хаагчийн ёс зүйн хэм хэмжээнд өдөр тутмын хяналт тавьж, төрийн захиргааны албан тушаалтны сул орон тоог Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдэгдэж, хуулийн хүрээнд шийдвэрлүүлэн, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зарчмыг баримтлан ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдах ажилтны 03 шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан, биелэлтийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 1/11299 дугаар албан бичгээр ирүүлсэн “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх, урьдчилсан үзлэгийг явуулах төлөвлөгөө”-ний дагуу ERP E-mongolia системийн сургалтад хамрагдаж, 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хэрэглээндээ нэвтрүүлэн ашиглаж байгаа бөгөөд хэлтсийн архивын үзлэгийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан талаар урьдчилсан байдлаар онлайн шалгалтад бүрэн хамрагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 15 дугаар хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/2450 дугаар албан бичиг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 1/10933 албан бичиг болон төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд тус аймгийн анхан шатны нэгж болох 13 сум, 1 тосгон, иргэний бүртгэлийн тасгийн 4, нийт 18 улсын бүртгэгч нарт гадаад паспортын бүртгэл хөтлөх эрхийг нээж, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн эд хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх эрхийг Баяннуур, Булган, Сагсай сумдын улсын бүртгэгч нарт 2025 оны 09 дүгээр сарын 20-оос нээж бүртгэл хөтлөх ажлыг эхлүүлсэн.

Хөдөлгөөнт явуулын үйлчилгээгээр аймгийн ахмадын хороонд ажиллаж 9 ахмад настан, төрийн банкны төв салбарын 12 иргэнд тус тус тоон гарын үсэг, хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэний ар гэрээр нь очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

Сумдын улсын бүртгэгч нар алслагдсан багийн иргэдийн нийтийн хуралд оролцож үндэсний гадаад паспортын үйлчилгээ 15, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 4, төрсний бүртгэлийн дахин олголтын гэрчилгээ 3, тоон гарын үсэг 30, иргэний үнэмлэх дахин захиалах /e-mongolia/ 7, төрсний гэрчилгээ шинээр авах 2, иргэний үнэмлэх захиалах үйлчилгээ 8 иргэнд тус тус үзүүлсэн бол аймгийн төвөөс алслагдсан Өлгий сумын 7-р баг буюу “Хотгор” багт ажиллаж үндэсний гадаад паспорт 8, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 1, төрсний бүртгэлийн дахин олголтын гэрчилгээ 1, иргэний үнэмлэх дахин захиалах /e-mongolia/ 3, тоон гарын үсэг 25 олгож ажилласан байна. Тайлант хугацаанд зөөврийн тоног төхөөрөмжөөр нийт 133 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар

Иргэний улсын бүртгэлийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх, Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэгчийг мэргэжлийн арга зүйгээр ханган дээд шатны байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 3/432 дугаартай албан бичгийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс хойш бүртгэгдсэн 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэх солиулахаар биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж иргэний үнэмлэхний сунгалт хийлгэсэн иргэдийн хэвлэгдэж ирсэн иргэний үнэмлэхийг шалгахад илэрсэн зөрчил гараагүй.

- Иргэний үнэмлэхийн бүртгэлд анх удаа, эсхүл 25, 45 нас хүрсэн иргэнд сольж олгохдоо иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлийн төрлийг сонгохдоо буруу сонгосноос шалтгаалан иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацааны мэдээлэл зөрчилтэй бүртгэгдснээр хэвлэгдэж байгаа талаар УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2025 оны 3/1017 дугаартай зөвлөмжийг баримтлан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байгаа болно.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын ИУБГ-ын даргын 2025 оны 3/1017 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмж хүргүүлэх тухай чиглэлийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр ИУБТ-ийн төвийн улсын бүртгэгч нар болон сумдыг хариуцан ажиллаж байгаа улсын бүртгэгч нарт “Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд гарч буй зөрчил цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалтын хөтөлбөр гарган хэлтсийн даргаар батлуулан сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулан ажилласан.

- УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газраас 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Иргэний улсын бүртгэл, гадаад паспортын бүртгэлийг хөтлөхөд анхаарах” сэдэвт зохион байгуулсан сургалтад хөтөлбөрийн дагуу улсын ахлах бүртгэгч Д.Аманбек, улсын бүртгэгч Х.Мейрам, С.Гүлжан, А.Алтангүл, Х.Харашаш нар онлайнаар хамрагдсан. Тухайн сургалтаар өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу 12 сумын улсын бүртгэгчийг “Улсын бүртгэлийн хууль тогтоомж, Авлигын эсрэг хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс гарах үр дагавар, хүлээх хариуцлага, цаашид анхаарах асуудлын талаарх” сэдвээр сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр цахимаар зохион байгуулж, сургалт зохион байгуулсан тухай илтгэх хуудсыг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

- Иргэний улсын бүртгэлийн газраас 2025 оны 05 дугаар сарын 12-оос 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хооронд Улаанбаатар хотод зохион байгуулсан “Иргэний ахлах бүртгэгч нарын нэгдсэн сургалт”-д төвийн нэг улсын бүртгэгчийн хамт оролцсон.

УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэх тухай Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 90 дугаартай мэдэгдлийн мөрөөр дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Ирсэн албан бичиг болон мөрдөгчийн мэдэгдлийг хэлтсийн дотоод группээр дамжуулан иргэний улсын бүртгэгч нарт мэдэгдлийг яаралтай хүргүүлэн танилцуулж, цаашдаа анхаарч ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн.

- Мөрдөгчийн мэдэгдэл болон Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн “Авилга, ашиг сонирхолын зөрчлийн талаарх ойлголт” сэдэвт сургалтын материалыг төвийн болон сумдын улсын бүртгэгч нарт онлайнаар сургалт зохион байгуулав. Уг сургалтанд төвийн иргэний бүртгэл хариуцсан 2, Буянт, Бугат, Сагсай, Толбо, Дэлүүн, Улаанхус, Өлгий сумдын нийт 10 улсын бүртгэгч оролцов. Бусад сумдын болон төвийн 2 улсын бүртгэгч нар ээлжийн амралттай гэх шалтгаанаар сургалтад хамрагдаагүй болно.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар

Улсын бүртгэлийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, улсын бүртгэгчийг мэргэжил, арга зүйгээр хангах, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн ажиллаж иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг зохих хууль журмын дагуу үнэн зөв хөтөлж шийдвэрлэн, удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухайд биелүүлж ажиллалаа. Үүнд:


- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5/529 дугаартай “Хяналтын улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлэх тухай”,
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 4/1903 дугаартай “Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай”,
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1/2058 дугаартай “Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай”,
- 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 5/5156 “Чиглэл хүргүүлэх тухай”,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 4/5158 “Чиглэл хүргүүлэх тухай”,
- 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 2/6507 “Зөвлөмж хүргүүлэх тухай”,
- 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 5/4982 дугаартай “Хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх тухай”,
- 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 5/6824 “Чиглэл, үүрэг даалгавар хүргүүлэх тухай”,
- 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 5/8635 “Санал ирүүлэх тухай”,
- 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 5/8792 “Мэдээлэл хүргүүлэх тухай” зэрэг албан бичгээр ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь илтгэх хуудсаар хүргүүлэн ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баян-Өлгий аймгийн хэмжээнд Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Улаанхус, Бугат, Буянт, Сагсай, Толбо, Цагааннуур зэрэг 8 суманд үзүүлж байгаа ба “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд дээрх 8 суманд хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг мөн үзүүлж эхэлсэн. Ингэснээр төвлөрлийг сааруулах, бүртгэлийн үйлчилгээг анхан шатанд шилжүүлэх

ажил амжилттай хэрэгжиж, тайлангийн хугацаанд 703 бүртгэлийг засаг захиргааны анхан шатны нэгж болох сум орон нутгаас үзүүлсэн байна.

Хэлтсийн даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 09-р сарын 22-ны өдрөөс 10-р сарын 10-ны хүртэлх хугацаанд хуулийн этгээдийн бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл суманд үзүүлэх боломжтой “эрх зүйч” мэргэжилтэй Баяннуур, Булган, Сагсай сумдын улсын бүртгэгч нарыг хэлтсийн төвд чиглүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулсан. Өнөөдрийн байдлаар хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээгдэж, эд хөрөнгийн бүртгэл хөтлөх эрх олгох тушаал УБЕГ-аас гараагүй хүлээгдэж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн тоо /сумдад/



2025 оны 04-р сарын 11-ны өдрийн 5/5156 чиглэл, 2025 оны 05-р сарын 16 ны өдрийн 5/6824 дүгээр албан бичгээр ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд аймгийн тойргийн нотариачидтай уулзалт зохион байгуулж, зуучлалын үйлчилгээг дундын мэдээллийн сангаар дамжуулан хүлээн авч онлайн мэдүүлэг цэсийг улсын бүртгэгч К.Еркед хариуцуулж тогтмол хянаж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 2 бүртгэл ирсэн бөгөөд тухайн үед нотлох баримт дутуу учраас шийдвэрлэх боломжгүй тайлбарлан буцаасан байна.






Гурав. Бүртгэлийн үйл ажиллагаа

3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд тайлант хугацаанд нийт 23836 иргэн хамрагдсан. Үүнд:

Д/д	Үйлчилгээний нэр, төрөл		Тоон үзүүлэлт
1	Төрсний бүртгэл		2045
2	Хүүхэд үрчлүүлсний бүртгэл		76
3	Овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл		56
4	Эцэг, /эх/ тогтоосны бүртгэл		12
5	Гэрлэсний бүртгэл		464
6	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл		54
7	Нас барсны бүртгэл		469
8	Иргэний үнэмлэх олголт		3142
9	Үндэсний энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтийн олголт		5776
10	Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл		3725
11	Шилжилт хөдөлгөөний бүртгэл		981
12	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл		1548
13	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголт		382
14	Нөхөн бүртгэл		165
15	Лавлагаа	Иргэнд	3536
		Албан хэрэгцээнд	256
		Хууль хяналтын болон төрийн байгууллагад албан тоотоор	1149
НИЙТ			23836



Харьцуулсан тоон үзүүлэлт

Тайлант хугацаанд 13497 бүртгэлийн 34271 хуудас материалыг цахимжуулсан байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтээсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор төрөлтийн 357, гэрлэлтийн 25, нийт 382 иргэнд гэрчилгээ олгов.

Тайлангийн хугацаанд 4 иргэний регистрийн дугаарыг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр нас тогтоолгосон болон регистрийн дугаар өөрчилсний бүртгэлд бүртгэж, регистрийн дугаарыг өөрчлөн Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр хүргүүлж ажилласан.

Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр үрчлэлт хүчингүй болсон 35 иргэний хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд бүртгэл хөтлөж, ерөнхий газарт хүргүүлж, хууль журмын иргэний цахим мэдээллийн санд үрчлэлтийг нь хүчингүй болгосон.


Гадаадын иргэн, харьяалалгүй хүний иргэний улсын бүртгэлийн гэр бүлийн байдлын бүртгэлд 19 иргэний өргөдлийг хүлээн авч хуулийн дагуу бүртгэсэн. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяалалгүй иргэний төрсний бүртгэл 13,
- Гэрлэсний бүртгэл 2,
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1,
- Эцэг тогтоосны бүртгэл 1,
- Нас барсны бүртгэл 2 тус тус бүртгэж, бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулан, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон.

3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Д/д	Орлого, тэмдэгтийн хураамж нэр төрөл	Мөнгөн дүн /төгрөг/
1	Үйлчилгээний хураамжийн орлого	211.520.844
2	Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдснаас оруулсан татварын орлого	546.742.573
3	Улсын тэмдэгтийн хураамж	8.313.707
Улсын болон орон нутгийн төсөвт нийт 766.577.124 /Долоон зуун жаран зургаан сая таван зуун далан долоон мянга нэг зуун хорин дөрөв/ төгрөг төвлөрүүлсэн.		



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хөлс, тэмдэгтийн хураамж

Тайлангийн хугацаанд нийтдээ 8835 мэдүүлэг, онлайнаар 37 мэдүүлэг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэснээс:

- Газар өмчлөх эрхийн бүртгэл 183 ,
- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 666,
- Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 101,
- Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл 38 тус тус бүртгэж, эрхийг нь баталгаажуулсан байна.

Мөн 1285 өмчлөх эрх шилжих гэрээ бүртгэж, баталгаажуулсан. Үүнд:

- ❖ Худалдах, худалдан авах гэрээ 886,
- ❖ Бэлэглэх гэрээ 169,
- ❖ Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 149,
- ❖ Шүүхийн шийдвэрээр 5,
- ❖ Хамтран өмчлөгч өөрчлөгдөх 70 бүртгэл тус тус бүртгэж баталгаажуулсан.


Арилжааны банкуудаар дамжуулан олгосон нийт 5439 барьцааны гэрээ бүртгэсэн. Үүнд:

- Барьцаалбартай барьцааны гэрээ 1138,
- Барьцаалбаргүй барьцааны гэрээ 1414,
- Барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 235,
- Барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 357,
- Түрээсийн гэрээ 5,
- Барьцааны гэрээ дуусгавар болгох 1260,
- МИК-иас барьцааны гэрээ дуусгавар болгох 37 бүртгэлийг онлайнаар бүртгэж, баталгаажуулав.

Бүртгэлд өөрчлөлт оруулах 862 бүртгэл бүртгэсэн. Үүнд:

- ✓ Үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгох 19,
- ✓ Өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх 3,
- ✓ Газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх 23,
- ✓ Гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох 1,
- ✓ Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 9,
- ✓ Эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх 222,
- ✓ Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 531 тус тус бүртгэж, баталгаажуулсан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон үзүүлэлт



Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 261 лавлагаа, 74 хуулбар олгож, 187 хувийн хэргийг хаасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн албан бичгээр эрх түдгэлзүүлсэн 300, эрх сэргээсэн 55 үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг цахим санд тусгасан байна. Түүнчлэн хөрөнгийн багцад тусгай тэмдэглэл 199 хийж ажилласан.


Архивт 1008 хувийн хэргийг шинээр хүлээн авч, 8835 хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэлт баяжилт хийгдсэн.

Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 102 лавлагаа мэдээллийг албан бичгээр хүргүүлэн ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс хаягийн зөрүүтэй 4 иргэний мэдээллийн зөрчлийг арилгаж шийдвэрлэсэн.

Хэлтсийн нэгжийн зохион байгуулалтаар төвийн 4 улсын бүртгэгч 2 нь мэдүүлэг хүлээн авах, 2 нь боловсруулалт хийх зарчмаар ажлын хуваарийн дагуу сар сараар солигдож ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн тоон үзүүлэлт



Тайлангийн хугацаанд нийт 8835 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэнд дүн шинжилгээ хийж үзэхэд 1 улсын бүртгэгчид өдөрт дундажаар аймгийн төвд 15-25, суманд 2-3 бүртгэл ногдож байна.

Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /eprs/ цахим системд ажиллах, бүртгэл хөтлөх талаар zoom-ээр эрх зүйн чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан.

Бүртгэлийн эх нотлох баримтыг бүрэн гүйцэт хүлээн авах, эх нотлох баримтыг баталгаат шуудангаар хугацаанд нь хэлтсийн архивт хүргүүлж байгаа эсэхэд улсын ахлах бүртгэгч тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 733 бүртгэл хөтөлсөн байна. Үүнд:

Д/д	Үйлчилгээний төрөл	Бүртгэлийн тоо
1	Шинээр бүртгэсэн ХХК	165
2	Төрийн бус байгууллага	36
3	Хоршоо	67
4	Сан	1
5	Боловсролын сургалтын байгууллага	5
6	Төрийн байгууллага албан газар	1
7	Нөхөрлөл	6
8	Салбар	11
9	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл	296
10	Дахин гэрчилгээ	35
11	Нэрийн баталгаажуулалт	110

Тамга тэмдгийн хяналтын 314 дугаар олгож, оноосон нэр өөрчлөгдсөн болон ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 50 тэмдэг хурааж авсан.

Сар бүр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээ гарсны дараа архивтай мэдээгээ тулган нягталж байгаа. 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 3342 хувийн хэрэг архивт хадгалагдаж байна.


БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭГЧ НАРЫН БҮРТГЭСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Сумын нэр	Бүртгэгчийн нэр	Бүртгэлийн тоо	Оноосон нэрийн баталгаажуулалтын тоо
1	Алтай	Д.Болормаа	18	-
2	Алтанцөгц	А.Бадамсүрэн	5	1
3	Баяннуур	Д.Тойжан	7	2
4	Бугат	С.Лена	2	1
5	Буянт	С.Жаргалсайхан	4	1
6	Дэлүүн	С.Рысбай	36	12
7	Улаанхус	Б.Бахытгүл	13	1
8	Цагааннуур	Б.Айсауле	5	2
9	Өлгий	Х.Тилеубек	220	48
10	Өлгий	Д.Нина	383	83
11	Өлгий	Ш.Еркинбек	33	1
12	Өлгий	К.Ерке	3	2
НИИТ			729	154

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд зөрүүтэй бүртгэгдсэн болон тамга, тэмдгээ үрэгдүүлсэн 4 хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч дүгнэлт гаргуулахаар хяналтын улсын байцаагчид шилжүүлж, дүгнэлт гаргуулан бүртгэсэн.

Тайлант хугацаанд шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 623 бүртгэлийн бүрдүүлбэр, бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон үзүүлэлт



Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж удирдлагад танилцуулан ажилласан. Тухайлбал, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа, шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой бүртгэсэн бүртгэлийн тайланг холбогдох судалгааны хамт хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ХХК цахимаар болон биечлэн ирж хэрхэн бүртгүүлэх талаар фэйсбук, сошиал сүлжээгээр олон нийтэд түгээн ажилласан.

Мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, төрийн бус байгууллагын тайлан, санхүүгийн тайлангаа гаргаж холбогдох байгууллагад илгээгээгүйн улмаас улсын бүртгэлээс хасагдах жагсаалтад орсон хуулийн этгээдийн талаар орон нутгийн радиод 2 удаа ярилцлага мэдээлэл өгсөн. Түүнчлэн хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээлгэсэн сумдын улсын бүртгэгч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан.



Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 97 албан тоот, 4 өргөдлийг хүлээн авч хариутай албан тоот, өргөдөлд хуульд заасан хугацаанд хариу хүргүүлж ажилласан.


Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах аймгийн ажлын хэсэгт тус аймагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн шашны болон төрийн бус байгууллагуудын талаар танилцуулга, холбогдох дэлгэрэнгүй судалгааг журамд заасны дагуу хүргүүлж ажиллав. Аймгийн ЗДТГ-т тус аймагт үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн төрийн бус байгууллагууд, шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой шинээр байгуулагдсан хоршоод, соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн судалгааг, цагдаагийн газарт тус аймагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн бүх хуулийн этгээдийн судалгааг гаргаж тус тус хүргүүлсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/07 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд 81 хуулийн этгээдийн дэлгэрэнгүй судалгааг журамд заасны дагуу аймгийн ИТХ болон цагдаагийн газарт хүргүүлж ажилласан байна.

3.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 2025 онд давхардсан тоогоор нийт 16133 бүртгэлд байнгын хяналт тавьж шалгасан байна. Үүнээс:

- Иргэний улсын бүртгэлийн 4967 бүртгэл,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 4862 бүртгэл,
- Хуулийн этгээдийн 2390 бүртгэл,
- Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 2753 бүртгэлийн эх нотлох баримтад байнгын хяналт тавьж шалгасан.



Илрүүлсэн зөрчлийг ангилж үзвэл:

- Иргэний улсын бүртгэл 165,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 160,

- Хуулийн этгээдийн улсын бүртгэл 127,
- Архивын зөрчил 49-ийг тус тус илрүүлсэн.


Илрүүлсэн зөрчлийн хүрээнд 122 хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 2535 иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох эрх зүйн нөхцөл байдлыг эх нотлох баримтыг үндэслэж тогтоон шийдвэрлэж, зөрчлийг арилгасан.

Түүнчлэн 130 хяналтын улсын байцаагчийн мэдэгдэл, албан шаардлага үйлдэн 3105 иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд хуульд заасан үндэслэлээр хүргүүлэн ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 9, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 165, гүйцэтгэлийн хяналт шалгалт 10 хийж илрүүлсэн зөрчилд тэмдэглэл үйлдэж, зөрчил арилгуулах тухай 6 албан шаардлагыг хэлтсийн /ахлах/ улсын бүртгэгч нарт хүргүүлэн, зөрчил арилгах арга хэмжээг авч ажилласан. Давхардсан тоогоор улсын бүртгэгч нарын хөтөлсөн 13972 бүртгэлд байнгын хяналт тавьсан.

Тайлангийн хугацаанд 225 иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч, хууль журмын дагуу хянан шалгаад хариу өгсөн бол 65 иргэний өргөдөл, гомдол хуульд заасан шаардлага хангаагүй тул буцаасан байна.

Мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, хууль, журам зөрчсөн 428 иргэн, 14 хуулийн этгээд, нийт 442 зөрчлийг Зөрчлийн тухай Монгол улсын хуулийн холбогдох заалтаар шалган шийдвэрлэж нийт 16.015.000 (арван зургаан сая арван таван мянга) төгрөгийн хүү торгууль оногдуулж, Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлт хангуулан ажилласан байна.



Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Цахим гарын үсгийн тухай хууль эцэслэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн иргэдэд олгож эхэлснээс хойш тус хэлтсээс 63531 иргэн тоон гарын үсгээ авчээ. Үүнээс гар утасны Gsign аппликейшнд 16434, иргэний үнэмлэхэд 50650 иргэн тус тус тоон гарын үсэг аваад байна.

Харин 2025 оны хувьд тайлант хугацаанд нийт 6783 иргэн тоон гарын үсэг авснаас Gsign аппликейшнд 6290, иргэний үнэмлэхэд 493 иргэн тус тус тоон гарын үсэг авсан.

Тоон гарын үсэг олголтыг нэгжээр харуулбал 2025/01/01-2025/11/10

Аймаг	Сум	Киоск		Нэгж		Нийт
		Гар утасны Gsign app	Иргэний үнэмлэх	Гар утасны Gsign app	Иргэний үнэмлэх	
Баян-Өлгий	Хэлтэс			1,387		1,387
	Алтай			102		102
	Алтанцөгц			290		290
	Баяннуур			433		433
	Бугат			273		273
	Булган			470		470
	Буянт			266		266
	Дэлүүн			535	4	539
	Ногооннуур			450	1	451
	Сагсай			177		177
	Толбо			324		324
	Улаанхус			504		504
	Цэнгэл	258	52	686		996
	Өлгий	40	436	95		571
Нийт		298	488	5,992	5	6,783

Хүснэгт 2. Нэгжийн тоон гарын үсэг олголтын тоон үзүүлэлт


Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

2025 оны байдлаар иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр 8 төрлийн бүртгэл ИУБ-11 төрөлт 2045 ширхэг, ИУБ-12 үрчлэлтийн бүртгэл 76, ИУБ-13 овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 56 ширхэг, ИУБ-12 эцэг /эх/ тогтоосны бүртгэл 12 ширхэг, ИУБ-15 гэрлэлтийн бүртгэл 465 ширхэг, ИУБ-16 гэрлэлт цуцалсны бүртгэл 54 ширхэг, ИУБ-18 нас баралтын бүртгэл 469 ширхэг, ИБЗ-1 мэдээлийн санд нөхөн бүртгэлд оруулсан маягт 54 ширхэг, биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэлд хамрагдсан ИУБ-31 маягт 4142 ширхэг зэрэг нийт 7319 маягтуудыг журмын дагуу хүлээн авч бүртгэж, хүлээн авах тэмдэг дарж, баримтыг төрөлжүүлэн ангилан хувийн хэрэгт баяжилт хийсэн. ХААТР-22 1484 ширхэг маягт хүлээн авч, хадгалах журмын дагуу хадгалагдаж байна. Одоогийн

байдлаар иргэний бичиг баримтын архивт 176545 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Бусад аймаг, нийслэлээс шилжиж ирсэн, биеийн давхцахгүй өгөгдөлд хамрагдсан, нас барсан, гэрлэсэн, төрөлт бүртгүүлсэн иргэний нийт 652 гаруй маягтыг хүлээн авч, бүртгэж хүлээн авах тэмдэг дарж байршуулсан байна.

Баримт бичиг нятлан шалгах комиссоор “Баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт”-аар хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй болсон баримтыг цаашид архивт хадгалах шаардлагагүй гэж үзсэн баримт бичгийн жагсаалт үйлдэж Баян-Өлгий аймгийн “Суат” ХХК-ний уурын зууханд нийт 345 бүрдүүлвэр, 66 бүртгэлийн дэвтэр, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг зэргийг тус тус устгалд оруулж, биелэлтийг ерөнхий газарт хүргүүлж ажилласан. Мөн 2026 онд устгалд оруулах бичиг баримтын жагсаалтыг гаргаж, ерөнхий газрын баримт бичиг нягтлан шалгах комисст хүргүүлэв.



Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 1008 хувийн хэргийг шинээр хүлээн авч, 8835 хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэлт, баяжилт хийсэн байна. Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 36418 хувийн хэрэг, хуулийн этгээдийн бүртгэлийн архивт 3342 хувийн хэрэг зохих журмын дагуу хадгалагдаж байна.

Мөн 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр архивуудын өрөө тасалгаанд мэргэжлийн байгууллагаар хортон шавьж, мэдрэгчийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн.



Байгууллагын архивт нэмэлтээр хийгдсэн ажлууд:

“Галын аюулгүйн булан”-д багаж хэрэгсэл, галын хор, жотуу, хүрз, болон гал унтраах бусад хэрэгсэл, элс зэргийг нэмж байршуулан гаднах хайрцгийг сэргээн засварлав.



“Архивын зориулалтын барилга, өрөө, тасалгаанд тавигдах шаардлага” стандартын дагуу хадгаламжийн өрөөний цонхонд нарны гэрэл бууруулагч наалт нааж, гаднаас харагдахааргүй болгож байгалийн гэрлийн нөлөөг багасгасан.

Мөн архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлыг хангах зорилгоор архивын өрөөний хаалганд босго шинээр хийсэн.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/177 дугаар “Улсын бүртгэлийн байгууллагын брэндбүкийн загвар батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж архивын хувийн хэргүүдийг хаягжилтийг шинэчилсэн.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 1/11299 дугаар албан бичгээр ирүүлсэн “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх урьдчилсан үзлэгийг явуулах төлөвлөгөө”-ний дагуу ERP E-mongolia системийн сургалтад хамрагдаж, 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хэрэглээндээ нэвтрүүлэн ашиглаж байгаа

ба архивын улсын үзлэгийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан талаарх ерөнхий газрын урьдчилсан онлайн шалгалтад бүрэн хамрагдсан байна.

Зургаа. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт

ХЗДХЯ-наас 2022 оны 3/5952 дугаар албан бичгээр "ХЗДХЯ-ны салбарын цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем"-ийн нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ERP E-mongolia системийн сургалтад хамрагдаж, 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. ERP E-mongolia программыг чиглэлийн дагуу нэвтрүүлж, албан хаагчдыг мэдээллээр ханган, шинэ программаар албан бичгийг илгээж, ирсэн албан бичиг, өргөдөл гомдол, санал хүсэлтийг даргад танилцуулан, холбогдох албан тушаалтанд цохолт хийлгэж, бүртгэж, хяналтын карт хөтлөн, хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн E-DOC болон ERP E-mongolia байгууллагын удирдлагын цогц программд бүх төрлийн бичиг хэрэг хөтлөлт хийж холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлж, шийдвэрлэлт болон хариутай албан бичигт хяналт тавьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй.

Тайлангийн хугацаанд хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 1140 албан бичиг хүлээн авч, нийт 1159 албан бичиг гадагш явуулсны 891 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг байна.

Мөн тайлант хугацаанд хэлтсийн даргын “А” тушаал 10, “Б” тушаал 5, нийт 15 тушаал гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Оны эхнээс иргэдээс нийт 62 өргөдөл хүлээн авч, холбогдох албан хаагч бүрт танилцуулан хуваарилан хуулийн хугацаанд шийдвэрлүүлж, хяналт тавьж ажилласан. Дээрх 62 иргэний өргөдлөөс 61 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 0, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 1 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 98.4%-тай байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилж үзвэл иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа. Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг хэлтсийн 7042-7810, 7042-7766 дугаарын утас, bayan-ulgii@burtgel.gov.mn цахим хуудсаар хүлээн авч ажиллаж байна. Мөн өргөдөл гомдлын мэдээг загвар хүснэгтийн дагуу гаргаж, хуулийн хугацаанд ерөнхий газрын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд баталгаажуулан хүргүүлэн ажиллаж байна. Хэлтсийн цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын архивын тасгаас ирүүлсэн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 250 дугаартай албан бичгийн дагуу 2009-2022 он хүртэлх байнга болон 70 жил хадгалах архивын баримтыг Төрийн архивын мэргэжилтнээс зөвлөгөө авч, архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журмын дагуу хадгаламжийн нэгж болгон цэгцэлж, байнга хадгалах хугацааны хадгаламжийн 37 нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн 2 нэгж, нийт 39 хадгаламжийн нэгжийг аймгийн Төрийн архивт шилжүүлэв.



Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан (Байгууллагын цахим хуудас, санхүүгийн үйл ажиллагаа)

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын нээлттэй бодлогын баримт бичиг”, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/> цахим хуудсанд тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэлийн үйл ажиллагааны талаар 45 мэдээлэл байршуулж, олон нийтэд түгээх зорилгоор мэдээллийг фото зургийн хамт олон нийтийн социал сүлжээ буюу <https://www.facebook.com/bayanulgii.burtgel> фэйсбук пэйж хуудсаар мэдээллийг давхар түгээж ажиллаж байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан албан хаагч бүр шэйр хийх байдлаар мэдээллийг түгээн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 4100 дагагчтай бөгөөд 2025 онд социал хуудсаар дамжуулан 78 бүртгэлтэй холбоотой мэдээллийн түгээлт хийгдсэн байна.


Цахим хуудасны танилцуулга цонхонд нэгжийн бүтэц, албан хаагчдын мэдээлэл, ил тод цонхонд хүний нөөцийн ил тод байдал, шилэн данс, хурал, сургалт, семинарын зар, улирал, жилийн тайлан, хэрэглэгч таньд цонхонд түгээмэл асуулт, хариулт, нээлттэй ажлын байрны зар, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал, сар бүрийн тоон мэдээ, холбоо барих цонхонд

байгууллагын хаяг, байршил, ажиллах цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах цаг, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах утасны дугаар, шуудангийн хаяг зэргийг нээлттэй байршуулсан. <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/sar-buriin-toon-medeelel>

Нүүр хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео мэдээллүүд, аймгийн танилцуулга, түүх болон дурсгалт газрууд, фото зургийн цомог, мөн аймгийн далбаа, газрын зураг зэргийг бүрэн оруулсан.

Баннер хэсэгт төрийн үйлчилгээний E-mongolia цахим систем, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах Burtgel.mn систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээллэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.

Цахим хуудасны хөл хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google тар дахь газрын байршлыг харуулсан болно.



Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчдын 2024, 2025 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг тус хэлтсийн www.gov.mn цахим хуудасны Хүний нөөцийн ил тод цонхонд нээлттэй байршуулав.

<https://www.gov.mn/mn/organization/BurtgelBU/servicedocumentId=evaluation%20sheet&serviceld=f1a3b974-2e61-44fb-b71b-bc8b0da2af6b>

Шил ажиллагааны <https://shilen.gov.mn/home> цахим хуудсанд улирал бүр:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 18 үзүүлэлт,
- Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 7 үзүүлэлт,
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 29 үзүүлэлт,
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараахь мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал 6 үзүүлэлтийг тухай бүр цахим хуудасны холбоос, файл зургийн хамт хавсаргаж оруулсан.

2025 оны 1-р улиралд 96,22%-иар, 2-р улиралд 81,89%, 3-р улиралд 86,2%-иар тус тус үнэлэгдсэн.

Санхүүгийн чиглэлээр:

Хэлтэс нь батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны 10 сарын байдлаар улсын төсвөөс 1.225.117.100 төгрөг, нэмэлт санхүүжилтээр аймгийн ЗДТГ-аас орон нутагт ажилласны нэмэгдэл хөлс 56.610.408 төгрөг, нийт 1.272.484.317 төгрөгийн санхүүжилт авснаас 1.138.982.426 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан нь нийт төсвийн 99.0%-ийн гүйцэтгэлтэй байна.

Мөн тайлант хугацаанд 141.666.667 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байснаас 91.828.141 төгрөгийн үйлчилгээний орлого оруулж, улсын төсөвт 91.828.141 төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 64%-ийн биелэлттэй байна.

Сар бүрийн 02-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан, өглөг, авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээ, үнэт цаасны зарцуулалт, үлдэгдэл, иргэний үнэмлэхийн орлогын тайлан зэргийг ерөнхий газарт тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Түүнчлэн ХАОАТ, НДШ-ийн тайлангуудыг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Хэлтсийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэж “Зөрчилгүй” дүгнэлт авсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүдийг тухай бүр 100, сар бүр 40, хагас жилээр 4, жил бүр 5 удаа тус тус хуульд заасан хугацаанд оруулж ажиллав.

Төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд 2025 оны төсөв, орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтын сарын мэдээг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан.

2026 оны төсвийн төслийг боловсруулж ерөнхий газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 15.735.700 төгрөгийн үнэт цаас, 3.660.580 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч санхүүгийн тайланд орлогод авч тусгасан байна.

Хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эд хөрөнгийн тооллогыг хагас жилийн байдлаар хийж, “Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ”-г албан хаагч бүртээ байгуулан, эд хариуцагчийн дэлгэрэнгүй картыг журмын дагуу хөтлөн ажиллаж байна.

Найм. Сургалтын төлөвлөгөөг тайлагнах ажлын хүрээнд

2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр иргэний улсын бүртгэлийн тасгийн төвийн улсын бүртгэгч болон сумдын улсын бүртгэгч нарт “Биеийн давцахгүй өгөгдлийн бүртгэлд гарч буй зөрчил, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалт, иргэн хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр шинээр томилогдсон болон сэлгэн ажиллаж байгаа албан хаагчдад Улсын бүртгэлийн хууль тогтоомж, бүртгэл хөтлөх журам, бүртгэлийн материалын бүрдлийг нягтлах, бүртгэх талаар 5 удаагийн сургалт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх

тухай холбогдох эрх зүйн 5 удаагийн сургалтыг хяналтын улсын байцаагч нар тус тус танхим болон цахимаар сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн прокурорын газраас эрх бүхий албан хаагч нарт зориулсан 2 удаагийн зөвлөгөөн, 5 удаагийн сургалт, Авилгатай тэмцэх газрын 1 удаагийн сургалт, Цагдаагийн газрын 2 удаагийн сургалтад алба хаагч нар танхимаар хамрагдсан.

Дотооддоо зохион байгуулсан сургалтууд:

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн худалдаалахтай тэмцэх тухай” үндэсний хөтөлбөр болон дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазны ахлах зөвлөх Д.Аянагүл, тус хэлтсийн хяналтын улсын байцаагч А.Еркегүл нар хамтран албан хаагчдад зориулсан хууль эрх зүйн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Дотоод хяналт шалгалт хийх тухай А/26 дугаар тушаалын дагуу тус хэлтэст хийсэн Хяналт шалгалтын албан шаардлагын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 07-нд бүртгэлийн зөрчлийг хэрхэн арилгаж буй байдалд хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах тухай арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, дахин зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан.



Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн 2025 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд

амжилттай зохион байгуулагдсан. Уг сургалтын талаарх мэдээллийг хэлтсийн нийт албан хаагчдад танилцуулсан.



Баян-Өлгий аймагт хүүхдийн нас баралтыг бүртгэлгүй үлдээх, улмаар нийгмийн халамжийн сангаас хууль бусаар тэтгэмж авах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалтыг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс хамтран зохион байгуулсан. Сургалтаар “Хүүхдийн нас баралтыг Улсын бүртгэлд заавал бүртгэх шаардлага, хууль эрх зүйн зохицуулалт”, “Нийгмийн халамжийн сангаас хууль бусар мөнгөн тэтгэмж авах, нийгмийн халамж, үйлчилгээ авах гэмт хэргийн хуулийн хариуцлага”, “Эрүүл мэнд, бүртгэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах арга зам” зэрэг сэдвээр явагдсан.

Сургалтад хамрагдсан байгууллагууд:

- ❖ Өлгий сумын 13 багийн Засаг дарга, нийгмийн ажилтнууд
- ❖ Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар
- ❖ Аймгийн Эрүүл мэндийн газар болон Нэгдсэн эмнэлгийн холбогдох мэргэжилтнүүд тус тус оролцсон.

Сургалтаар энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс иргэдийг урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээллээр хангах ажлыг цаашид аймгийн хэмжээнд буюу үлдсэн 12 сумын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээг шат дараатай зохион байгуулахаар харилцан тохиролцов.



"Өлгий ертөнц" ХХК-ний сургагч багш, цагдаагийн бэлтгэл хошууч К.Ёлка "Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх нь" сэдэвт

сургалтыг танхимаар болон сумдын улсын бүртгэгч нарт цахимаар зохион байгуулсан.

Мөн түүнчлэн “Өнөөдөр нийгэмд тулгамдаж буй асуудал, хүүхдийн хүмүүжил төлөвшилд хэрхэн анхаарах, эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх” талаар алба хаагч нартай ярилцлага өрнүүлсэн өргөн хүрээтэй сургалт болсон.



- ❖ “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүртгэл хөтлөхөд гарч буй алдаа дутагдлыг арилгах” сэдэвт сургалтыг хяналтын улсын байцаагч А.Еркегүл,
- ❖ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх кибер аюулгүй байдал” сэдэвт сургалтыг аймгийн цагдаагийн газрын цагдаагийн ахмад М.Жанарыс,
- ❖ “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн платформ Ерр систем” сэдэвт сургалтыг архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав Е.Галия,
- ❖ “Мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт сургалтыг мэдээлэл, технологийн ажилтан Т.Батырхан,
- ❖ “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын талаарх сургалтыг хэлтсийн захиргааны ахлах мэргэжилтэн Х.Амангүл,
- ❖ “Иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Аманбек,
- ❖ “Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ш.Еркинбек,
- ❖ “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй зөрчлүүд” сэдэвт сургалтыг хяналтын улсын байцаагч А.Еркегүл,
- ❖ “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх” сэдэвт сургалтыг улсын бүртгэгч К.Ерке,
- ❖ “Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл хөтлөх” сэдэвт сургалтыг улсын бүртгэгч Д.Нина нар тус тус зохион байгуулж, алба хаагч нарт мэдээлэл өгөв.



Ес. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах (Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал)

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай нягт хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг түргэн шуурхай хүргүүлэн ажилласан.

“Цахим засаглал” хөтөлбөр, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх ажлын хүрээнд аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, удирдлагуудтай хамтран ажиллах санал хүргүүлснээр орон нутгийн хөгжүүлэх сангаас 2025 онд нийт 56,800,000 /тавин зургаан сая найман зуун мянга/ төгрөгийн дэмжлэгийг орон нутгаас шийдвэрлүүлэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Сагсай сум улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 23.000.000 төгрөг,
- ❖ Цахим гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээнд шаардлагатай фото аппарат 6 ширхэг /Булган, Дэлүүн, Баяннуур, Ногооннуур, Алтай, Цэнгэл сум/ 13.800.000 төгрөг,
- ❖ Баяннуур сум улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 25.000.000 төгрөг,



Аймгийн Засаг дарга Е.Зангар хэлтэс, агентлагийн дарга нар болон сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах үр дүнгийн гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээ нь Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, сумын хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэж байна.

Мөн гэрээнд талуудын хүлээх үүрэг, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл, хэрэгжилтийг дүгнэх, үнэлэх журмуудыг тусгаж, хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг салбар бүрээр тодорхойлсон юм.

Дүрвэгсдийн эрх хамгааллын ахлах мэргэжилтэн Монгол Улсад суугаа НҮБ-ын ДАДК-ын газраас “Дүрвэгсдийн эрх хамгаалал”-ын талаар холбогдох байгууллагын эрх бүхий албан хаагч нарт мэдээлэл өгөв.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 2025 оны 01 дүгээр сарын 24-нд зохион байгуулсан “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын дунд спортын 3 төрөлт тэмцээнд тус хэлтэс “НЭГДҮГЭЭР” байранд шалгарсан.



Монгол Улсын Засгийн газрын харьяа Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу Баян-Өлгий аймагт “Нээлттэй Засгийн түншлэл долоо хоног-2025” арга хэмжээг зохион байгуулж буйтай холбогдуулан тус аймгийн төв талбайд аймгийн ЗДТГ-аас өдөрлөг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд иргэдэд мэдээ мэдээлэл хүргэж, материал тараан, зөвлөгөө өгч ажилласан. " ХУУЛЬЧИЙН ПРО БОНО-2025" өдөрлөгт оролцож иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.



Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жил бүрийн 3 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл үндэсний хэмжээнд уламжлал болгон зохион байгуулдаг “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аянд нэгдсэн.



XVII жарны "Хөхөгчин" хэмээх модон могой жилийн сар шинийн баярыг угтан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагчид Монгол үндэсний өв соёлоо дээдлэн, зан заншлаа хүндэтгэн үндэсний хувцсаа өмсөж, сар шинийн баярын уур амьсгалыг бүрдүүлэн ажилласан.

Энэхүү уламжлалыг дэлгэрүүлснээр ард иргэддээ өв соёлоо хайрлан хамгаалах, үндэсний хувцасны хэв маяг, язгуур үзэл, соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



Толбо, Булган, Улаанхус, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Сагсай сумдын улсын бүртгэгч нар сумдынхаа багийн Иргэдийн нийтийн хуралд оролцож иргэдэд иргэний улсын бүртгэл болон эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, нас барсан хүүхдийг бүртгүүлээгүй тохиолдолд үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагын талаар мэдээлэл өгч ажилласан. Мөн 2 иргэнд E-Mongolia системээр гадаад паспорт захиалж, гадаад паспорт авах иргэний хүсэлтийн дагуу 2 хүүхдийн гадаад паспортын захиалгыг авч үйлчилгээ үзүүлсэн байна.






Иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд байгууллагуудын дундын мэдээлэл солилцох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, цахим нотариатын "Зуучлалын модуль" системээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд гэрээ, хэлцэл илгээх, бүртгэх талаар аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, тойргийн нотариатч нартай уулзалт зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцов.



Аймгийн төвөөс алслагдсан Өлгий сумын 7-р баг буюу "Хотгор" уурхайн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь очиж явуулын бүртгэлийн үйлчилгээг зохион байгууллаа. Үүнд:

- ❖ Гадаад паспорт захиалах 8,
- ❖ Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 1,
- ❖ Төрсний гэрчилгээ дахин олгосон 1,
- ❖ Иргэний үнэмлэх дахин захиалах /e-mongolia/ 3,
- ❖ Тоон гарын үсэг олгосон 25 иргэнд бүртгэлийн үйлчилгээг тус тус хүргэж төрийн үйлчилгээг иргэнд ойртуулсан онцлох ажил байлаа.



Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 250 гаруй ахлах ангийн сурагчдад иргэний улсын бүртгэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар мэдээлэл хүргэж ажиллав.

- 16 нас хүрсэн иргэний үнэмлэх шинээр авах,
- Гадаад паспорт захиалах,
- Гээгдүүлсэн, гэмтээсэн бичиг баримтаа дахин авах бүртгэл хөтөлж, нийт 15 сурагчдад тоон гарын олгов. Мөн сурагчдын сонирхсон асуултад хариулав.



Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар, салбарын хөдөө орон нутагт ажиллаж буй албан хаагчид болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрт илрүүлэг хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий аймгийн Хилийн цэргийн 0165 дугаар ангийн эрүүл мэндийн төвд 2025 оны 04 дүгээр сарын 15-21-ний хооронд эрүүл мэндийн үзлэг зохион байгуулагдсан. Уг эрүүл мэндийн үзлэгт тус хэлтсийн 25 албан хаагч, албан хаагчдын гэр бүлийн гишүүд 3, улсын бүртгэлийн ахмад албан хаагчид гэр бүлийн гишүүдийн хамт 4, нийт 32 хүн дараахь 6 үзүүлэлтээр үзлэг, шинжилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан. Үүнд:

- ❖ Цусны шинжилгээ өгөх (халдварт өвчин байгаа эсэх болон сахарын хэмжээг тодорхойлох)
- ❖ Зүрхний бичлэг хийлгэх
- ❖ ЭХО
- ❖ Дотрын эмчийн үзлэг, зөвлөгөө
- ❖ Мэдрэлийн эмчийн үзлэг
- ❖ Сэтгэл судлалын тест бөглөж, зөвлөгөө авах зэрэг үзлэг, үйлчилгээнүүд багтсан байна.



2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд явган алхалтын сарын аянд хэлтсийн алба хаагчид идэвхтэй оролцлоо.



Аймгийн Онцгой байдлын газраас 2025 оны 03 дугаар сарын 27-нд зохион байгуулсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургалт”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, аймгийн Засаг даргын тамгын газартай хамтарсан «Баруун бүсэд онцгой болон онц байдал бий болсон үеийн хамтарсан ажиллагаа явуулах нь» сэдэвт “Сөргө-2025” стратегийн команд штабын сургууль 2025 оны 09 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд дээрх сургалтуудад хэлтсийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн идэвхтэй оролцсон. Дээрх сургалтын хүрээнд хэлтсийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг аранзаар хангасан байна.



Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил

“Цахим засаглал” хөтөлбөр, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга сумын ИТХ, Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд Сагсай, Баяннуур сумдад Улсын бүртгэлийн /Киоск/ машин худалдан авч тухайн сумдын ЗДТГ-ын байранд байршуулан сүлжээнд холбож ашиглалтад хүлээлгэн өгч ажилласан.



Бүртгэлийн төвлөрлийг сааруулах, үндэсний гадаад паспортын үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай анхан шатны нэгжээс хүргэх ажлын хүрээнд аймгийн ИТХ, Засаг дарга нарт хүсэлт хүргүүлж, цахим гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээнд шаардлагатай фото аппарат Булган, Дэлүүн, Баяннуур, Ногооннуур, Алтай, Цэнгэл сумдын улсын бүртгэгч нарт шинээр олгож үйлчилгээнд ашиглаж эхэллээ.





Аймгийн “Нэг байгууллага - Нэг санаачлага” арга хэмжээний хүрээнд байгууллагын хүүхдийн төлөө хийж хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэлтсийн эцэг, эхийн зөвлөлийн санаачлагаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн 5 хүүхдэд гарын бэлэг гардуулж, баярлуулав.



Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагт үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан 🌳🌳🌳 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж уг зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор хуваарьт газарт хэлтсийн алба хаагч нар мод тарих ажилд идэвхитэй оролцож 84 ширхэг бургас мод тарьсан.




2024 онд 16, 25, 45 насанд хүрч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдаж иргэний үнэмлэх шинээр авах, дахин авах, сольж авах, иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авахад бүртгүүлэх материалтай хялбараар QR код уншуулан авах постер бэлдэж байгууллагын сошиал болон цахим хуудсаар түгээж ажиллав.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойд зориулсан “Спорт-2025” тэмцээнд “БАРУУН БҮС” буюу Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудын баг тамирчид идэвхтэй оролцож, нийлбэр оноогоор “ТЭРГҮҮН” байр эзэлж, “ЦОМ”-ын эзэд боллоо.



Мөн Монгол Улсад Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойг тохиолдуулан тус хэлтсийн дарга Д.Мягмаржав “Иргэний итгэл бол төрийн нэр хүндийн баталгаа юм” сэдэвт цуврал ярилцлагад өгч, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг “Надад тохиолдсон онцлох түүх” цахим контентыг бүтээж ерөнхий газарт хүргүүлж, фэйж хуудсанд нийтэлсэн.




Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн баярыг угтаж Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д үйл ажиллагаа явуулдаг албан байгууллагуудын дунд 11 дүгээр сарын 07-08-ний өдрүүдэд спортын уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хэлстийн нийт албан хаагчдад зохион байгуулсан сургалтын үеэр брэндбүкийг танилцуулж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах, батлагдсан бэлгэдлийг загварын дагуу байгууллагын баримт бичиг, үйл ажиллагаандаа хэрэглэж ажиллах талаар

мэдээллийг хүргэж ажиллалаа. Фэйсбүк дэх пэйж хуудас, өрөөнүүдийн хаалганы хаяг, самбар, албан хаагчдын ажлын үнэмлэх зэрэг бэлгэдлийг өөрчилж байршуулах ажлыг зохион байгуулсан.



Өлгий сумын Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/482 тоот албан бичгээр ирүүлсэн өвлийн улирал эхэлж байгаатай холбогдуулан Өлгий хотын орох гарах чиглэл болон гурван замын уулзвараас “Түмэн” хүнсний дэлгүүр хүртэл хуваарьт газарт их цэвэрлэгээ хийж цэвэрлэн, хог хаягдлыг ачиж хогийн нэгдсэн цэгт буулгаж, аймаг орон нутгийн олон нийтийн ажилд идэвхитэй оролцлоо.



ТАЙЛАН ГАРГАСАН:
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Д.МЯГМАРЖАВ